

дэлгүүр хоршоогоор бараа таваар элбэгээс ч юм уу, хүн ялаа батгана адил багширан оочирлох дугаарлах явдал ерөөс гардаггүй. Иймээс дэлгүүр дотор агаар цэнгэг, шороо тоос дарахгүй байна. Дэлгүүрүүд нь ч зайтай, чөлөөтэй байх ажээ. Харин талбай бага зарим дэлгүүрт бараа таваарыг ханаар зай завсаргүй жигдлэн өрсөн нь нарийн гудам гаргасан мэт. Хүнсний дэлгүүрт нь жилийн дөрвөн улиралд хүнсний ногоо, алим жимс ерөөс тасрах гэж байхгүй. Газрын бөмбөрцгийн хаа л бол хаанаас авчирж зарах тул худалдан авагчид үргэлж шинэ ногоо, шинэ жимсээр хангалттай байдаг байна.

Сайн хүн явснаа, муу хүн идсэнээ гэдэг үг байдгийг үл умартан өгүүлэхэд анх бидний Нью-Йоркад буухад угтаж авсан эрдэмтэд, Индианы их сургуулийн профессор Синор, Гомбожав нар (Биднийг угтаж авах гээд алс холын Индианаас ирсэн байсан) урьд АНУ-ын ерөнхийлөгч Рональд Рейганы орж байсан гэх «Анкл Тан»-ы (Тан өвгөний) гуанзанд бидэнд хятад хоолоор оройн зоог барьж, хуучилцагалаа. Хоолны амт шимтээс үзвэл үнэхээр Тан овогтны гэх нь аргагүй.

Ингээд эцэст АНУ-д байх хэдэн хоногт академийн төлөөлөгчид бидний ажил хэрэг түргэн бүтэмжтэй болоход НҮБ-д суугаа манай Бүрэн эрхт төлөөлөгч Нямдоо, Должинсүрэн болон бусад нөхөд ихэд тусласанд гүн талархсанаа тэмдэглэн үлдээе.

Монголын төлөөлөгчид бид хавар-зун халалцах заагийн урин дулаан цаг ирсэн, манай Монголынх шиг нэг цэлмэг сайхан өлзийт өдөр Америкийг орхиж, нутгийнхаа зүг мордлоо.

## **ЭЛЭГ ДЭВТЭЭСЭН УУЛЗАЛТ**

### **М. Зэнээ**

Удам угсаа, гарал үүсэл нэг Монголын ард түмэн уудам дэлхийд тархан суусан нь нэн олон. Тэдний нэлээд хэсэг нь улс гүрний хил хязгаарт таслагдан улмаар салж хөндийрсөн нь ч цөөнгүй. Саяхан болтол нэг монгол туургатанд нэгдэж явсан Өвөр Монголын ард түмэн Хятад улсын харъяанд үлдсэнээс хойш ах дүү, аав, ээж, амраг садан аль олон хүмүүс хилийн наана цаана таслагдан үлдэж, уулзаж учиралгүй нэлээд олон жил өнгөрснийг бид мэднэ.

Улс хоорондын харилцаа хэвийн найртай байхад ах дүү хүмүүс, хэдийгээр өөр өөр улсад амьдарч байсан ч сэтгэлээр өнчирдөггүй, уулзан учирч, элэг дэвтээж явдаг байна. Улс төрийн бодлого эвгүй тийш хандаж, улс хоорондын харилцаа хүйтэн хөндий болоход ард

түмэн, түүний дотор ах дүү үндэстнүүд бүр ч зовж зүдэрч, бие сэтгэлийн хувьд хүнд хэцүүг туулдаг ажээ.

Монгол-Хятадын ард түмний хооронд найрсаг харилцаа тогтсон 1950 оноос 1960-аад он хүртэл БНМАУ дахь монголчууд ба Хятад дахь Өвөр Монголчуудын хооронд жинхэнэ ах дүүгийн нөхөрсөг харьцаа тогтож өдөр ирэхүйяа өргөжин тэлж байсан билээ. Гэтэл 1958 оны «Баруунтныг эсэргүүцэх хөдөлгөөн», 1966-1969 оны «Соёлын хувьсгал», 1968 оны «Өвөр ардын намыг малтах хөдөлгөөн» зэрэг улс төрийн элдэв кампаниас болж монголчууд хоёр улсын хилийн заагаар таслагдан салж, ах дүү хүмүүс хоорондоо уулзах байтугай, захидал чимээ ч нэвтрэх боломжгүй болсон билээ. Улс төрийн бодлогын энэхүү таслалт хичнээн эх, үр, эхнэр, нөхөр, ах дүүгийн ариун сэтгэлийг цавчин хаясныг түүх мэднэ. Хятадад явагдсан улс төрийн энэ мэт дампуурлын үед ах дүү, төрөл садан нь Монголд амьдардаг өвөр монгол хүн бүрийг толгой дараалан хэлмэгдүүлсэн нь ч нууц бишээ. Энэ тухай Хятадын хэвлэлд өнөөдөр тодорхой бичиж байгаа нь тэнд сүүлийн жилүүдэд явагдаж байгаа «шинэчлэлт» ил тод байдлыг эрхэмлэж байгааг харуулах ажээ. Линь Бяо «Дөрвийн бүлэг»-ийн хорлолыг амссан Өвөр Монгол хүмүүс өнөөдөр цаг тайван болохоор БНМАУ-д байгаа ах дүүгээ сураглах, уулзаж учрахыг мөрөөдөх явдал их боллоо.

Амьд мэнд яваа ах дүү төрөл садан, аав ээж, үр хүүхэд уулзан учрахыг нүдээр харж, хоёр улсын нам төрийн харилцаа зөөлөрсөнд талархаж яваагаа илтгэсэн олон хүний сэтгэлийг уншигч олонтойгоо хуваалцах зорилгоор «элэг дэвтээсэн уулзалт» хэмээх энэ өгүүллийг бичлээ.

Хятадын Засгийн газраас БНМАУ-ын Гадаад явдлын Яаманд тавьсан нэг хүсэлтийг анхааран үзвэл ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн Баруун Үзэмчин хошууны харъяат «Дархан бөх» Эрхэмбат БНМАУ-д байдаг өөрийн төрсөн дүү Өлзийбаяртай уулзах гэсэн хүсэлт байсан юм. Эрхэмбат энэ үед «Соёлын хувьсгал»-ын үед хүнд хэцүүг бие сэтгэлээрээ туулан өнгөрөөгөөд олон жилийн хүнд хэцүү тарчлаалтаас болж улаан хоолойн өмөн үү тусч хоол орохоо болиод ходоодоо цоолуулан гуурсаар өдөрт нэг литр бантан хийлгэж амь зууж байсан юм. БНХАУ-ын АТИХ-ын гишүүн, Бүх Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн гишүүн Р. Эрхэмбат бүх насаараа Хятад улсад социализм байгуулах үйлсэд бие сэтгэлээ зориулж явсан хүндтэй хүн боловч хүнд хэцүү тамлалаас болж биегүй болоод байсан учир БНМАУ-д байгаа төрсөн дүү Өлзийбаяртай минь уулзуулж өгөөч гэсэн ганц хүсэлт тавьсаныг Хятадын шинэ удирдлага хүн ёсоор анхааран үзэж туслахаар шийдсэн нь энэ байжээ. Хятадын талын хүсэлтийг манай нам, засаг анхааран үзэж Эрхэмбатын дүү Өлзийбаярыг ахтай нь уулзуулах зөвшөөрөл олгосон тэр жил 1982 он байсан юм. Алдарт бөх Раднаагийн Эрхэмбат 1955 онд Шилийн гол аймгийн Баруун Үзэмчин хошуунд «эх булаг» нэртэй малжих талбай буюу анхны нэгдэл байгуулсан гавъяатай хүн билээ. Тийм ч учраас тэр 1966 он хүртэл БХАТИХ-н гишүүн, 1980-аад оноос Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн гишүүн /БХАУТЗЗ-н гишүүн/ тус тус байсан юм.

Р. Эрхэмбатыг «Соёлын хувьсгал» эхэлсний дараа хоёр жил шүүмжлээд дараа нь тусгай шийдвэр гарган баривчилж 7 жил хатуу дэглэмтэй, 2 жил хөнгөн дэглэмтэй ял эдлүүлсэн байна. ӨМӨЗО байгуулагдсаны 10 жилийн ойгоор 1957 онд болсон наадамд Монгол бөхийн манлайд шалгаран дэвж, зарим үед нэг жилийн олон хошууны наадамд 11 удаа барилдахад 9-д нь түрүүлж, 2-т нь үзүүрлэж явсан энэ алдарт бөхөд «Соёлын хувьсгал»-аар «Хар малгай» гэгчийг өмсгөж үг хэлэх эрхгүй, ямар ч хүний өмнө очсон нүглээ наминчлан толгой бөхийн зогсож өнгөрөөхөөс эхлээд үзээгүй юм гэж үгүй. Түүнийг тэргэнд хоёр хүний хамт хөллөж өдөржин мод чулуу, ус шавар зөөх бөгөөд «Тэрэгний хүрэн» нэртэй байжээ. Өдөр морь малын үүрэг гүйцэтгэн тэрэг чирч яваад ирэхэд орой нь улайтал гал түлсэн пийшин дээр хоёр гарыг нь ард нь үүрүүлж нүүрээр нь тонгойлгон зогсоож, нүглийг нь наманчлуулна.

Галтай пийшин дээр удаан хугацаагаар тонгойн зогсоход хамаг биений хөлс шар шар хийтэл халуун ширмэн дээр дуслана. Энэ үед «халууцаж байна уу?» гэж улаан хамгаалагчид асуугаад толгой дохиоор нь «одоо сэрүүцүүлнэ» гэж гэрээс түлхэж гаргана. Удаан гадаа зогсоход хамаг бие хэрч, хөл гар нь хөлдөнө. Олон удаагийн ийм тамлалаас болж үе үе ухаан алдан унана. Ийнхүү халуун хүйтэн хямарснаас болж өмнө өгүүлсэн улаан хоолойны өмөн үүтэй болж, насны галтайдаа зуурдаар таалал төгссөн нь энэ ажээ.

Эх орон ард түмнийхээ төлөө гэсэн чин сэтгэл өвөрлөн, социализм байгуулах үйл хэрэгт бие сэтгэлээ зориулан зүтгэж явсан жирийн нэг сайхан монгол эр ийнхүү гэнэтийн гүтгэлгэнд өртөн олон жил эрүү шүүлт үзсэн нь Хятадын хэвлэлд бичдэг Линь Бяо «дөрвөн хүний бүлэг»-ийн үйлдсэн тэнгэр тулам ял, «феодал-фашист диктатур» явуулсны гай билээ. Эрхэмбат төрсөн дүүтэйгээ элэг дэвтээн уулзсан 1982 онд «Соёлын хувьсгал» бол сахилгагүй хүүхэд ч гэнэ алдаж хиймээргүй тийм бүдүүлэг, зэрлэг алдаа байсан. Энэ хувьсгал хүн голж байсангүй. 80 настай хөгшин ч, 8 настай балчир ч өртөж байлаа» гэсэн нь уг хувьсгалын мөн чанарыг нэлээд бодитой тодорхойлсон дүгнэлт байлаа.

Миний бие 1970—1980-аад онд судалгаагаар явж байхдаа Монголд амьдарч байгаа, хятадын «Соёлын хувьсгал»-ын үед хэлмэгдсэн хүмүүстэй цөөнгүй уулзаж байсан. Тэдний нэлээд нь тэр үеийн тухай ярихдаа «Хоёр хүний хувцасыг тайлж дээлийг нь нөмгөн өмсүүлээд ар нуруугаар нь нийлүүлэн хүлж, хормой дотор нь керосинд дүрсэн амьд болжмор шатаан хийдэг байсан» тухай ярьж байж билээ. Асаж байгаа болжмор дээшээ л хөөрөөд байхаас доошоо унана гэж үгүй. Нүцгэн биенд хүрсэн газар болгоноо түлж цэврүү болгоно. Адилхан зовсон хоёр амьтан болохоороо болжмор нь хурдан шатаж үхээсэй гэж залбирдаг байлаа хэмээн ярьж байсан нь зовлон үзсэн хүний үнэн үг, байлаа. Хал зовлонгийн хатуу бүхнийг нуруун дээрээ үүрч өнгөрөөсөн өвөр монголчууд бэтгэрсэн элгээ дэвтээн, бие сэтгэлээ тайвшируулсан өнөөдөртэй ийнхүү золгосон баяр бахыг юуны өмнө Хятадын өнөөгийн шинэ удирдлагатай холбон үзэж, тэдэнд талархсан сэтгэлээ илэрхийлж байгаа нь цөөнгүй ажээ. Сүүлийн жилүүдэд хоёр улсад амьдарч байгаа ах дүү монголчуудын хооронд энэ мэт олон удаагийн элэг дэвтээсэн уулзалт болж байгаа нь манай

нам, засаг, ард түмний өгөөмөр сэтгэл, хувиршгүй байр суурь, зарчимч тууштай бодлогын илрэл гэж бас хэлэх ёстой хэмээн бид үздэг.

Хятадын төрийн шагналт, Өвөр Монголын алдарт дуучин М. Лхасүрэн, түүний гэргий БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд агсан Чжоу Эньлайн өргөмөл охин Чжоу Төмөрцэцэг, хүү Л. Зүрхээ, Хятадын төрийн шагналт, алдарт морин хуурч Чий Булаг, Хөгжмийн нэрт зохиолч Да. Самбуу, түүний гэргий хөгжимчин Төмөрчөдөр, Өвөр Монголын Ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн гишүүн Оюун, түүний гэргий Бо Минь, ӨМӨЗО-ы зохиолчдын хорооны орлогч дарга Б. Осор, Өвөр Монголын Хөх хот дахь Хятад-Монгол эмнэлгийн хорооны Монгол эмнэлгийн орлогч дарга, нэртэй эмч Жан, Базар, түүний гэргий Цэцэнгуа, Ляонин мужийн Фу Шиний монголчуудын өөртөө засах сяний (хуучны Монголжин хошуу) дарга агсан Овоо, түүний гэргий Дүүрэгч, Өвөр Монголын Шилийн гол аймгийн Баруун Үзэмчин хошууны сумын дарга Дүүрэнзанаа, Алшаа аймгийн Алшаа баруун хошууны малчин ах дүү гурав Дашмаа, Ёндон, Батбаатар нарын олон хүн ах дүү нарынхаа урилгаар сүүлийн жилүүдэд БНМАУ-д ирж айлчилсныг манай хоёр орны нам засгийн хайр ивээл гэхээс өөр юу гэх билээ. Эдний дотроос 44 жил уулзаж учраагүй гурван хүүхэдтэйгээ уулзсан 80 хүрч яваа хөгшин эхийн тухай өгүүлэхгүй өнгөрөх аргагүй. Улаанбаатар хотын Найрамдлын районд амьдарч байгаа 80 настай буурал Заяа овогтой Мөөг гуай уг нь одоогийн Говь-Алтай аймгийн Алтай сумын хүн юм. Тэр өссөн төрсөн нутгаа 13 настай балчир охин байхдаа орхин одсон гэдэг. Улс төрийн төөрөгдөлд энгийн номхон ард иргэдийг оруулж, ухуулга ятгалга хийж байсан гадна, дотны самууруулагчдын хатгалгаас болж Ардын хувьсгалын «аюул» гэгчээс дүрвэн зайлж, бурханы оронд очин сайн сайхан, амар жаргалтай амьдрахаар явагчдын сүүлчийн нэгхэн хэсэг 1923 оны мичин жил Утай Гүмбэн орохоор Говь-Алтай аймгаас хөдлөхөд энэ охин цуг явсан байна. «Эхнэрээсээ салсан хүн жил уйлдаг, Эх орноосоо салсан хүн насаараа уйлдаг» гэж монгол ардын зүйр үг байдаг нь гүн ухааны онцгой утгыг үнэнтэй цуг дотроо агуулж байдгийг манай ард түмэн сайн мэдэх билээ.

Халх нутгаас гарснаас хойш хал үзэж, халуун чулуу долоож, амьдралын түмэн нугачаа, мянган саадыг даван явсаар халх нутгаас өөртэй нь адил дүрвэн гарсан нэг монгол айлын хүү Жигмэдийн Пүрэвтэй тэр эмэгтэй айл гэр болон амьдарчээ.

Хүний амьдралын аз жаргалын бэлэг тэмдэг болсон залаг үртэй болоод байсан 1944 он буюу төрсөн нутгаасаа гарсаар 21 жил болсны дараа 3. Мөөг гуай төрсөн эгчдээ золгохоор хоёр улсын хил дээр ирсэн байна. Ханилсан хань, гурван нялх үрээ гэртээ орхиод эгчтэйгээ золгох гэж ирсэн Мөөг «Төрсөн нутаг, төрүүлж өсгөсөн ард түмнээ санан мөрөөдсөн» өөрийн нь эгчээс эхлээд хэд хэдэн айлын нүүдэлтэй тааран өдөр нь амарч, шөнө нь нүүх аян дагасаар БНМАУ-ын хилийн ихээхэн гүнд орж ирснээ ч анзаарсангүй. Монгол улсын хилд ойрхон байсан айлын нүүдлийг нутаг сэлгэсэн нүүдэл хэмээн эндүүрч, төрсөн эгчтэйгээ олон жил уулзаагүйн харгайгаар элдвийг хүүрнэн, хонон өнжин сэтгэл дэвтээсэн Мөөг хүүхэн гэртээ орхисон эр нөхөр, нялх үрээ санан буцах гэтэл байдал нэгэнт эргэсэн байжээ. Хэвлийдээ 5 сар болсон хүүхэдтэй ганц бие

эмэгтэй буцаад явахад тэмээгээр 7 хоног шогшуулах газар хоёр улсын хил давна гэдэг тийм санаан зоргын асуудал байгаагүй нь мэдээж хэрэг. Яагаад гэвэл 1944 он дайны цэвүүн цаг, олон улсын байдал нэн хүнд үе байсан болохоор давхар биетэй Мөөг хүүхнийг хил давуулан буцаахыг ах дүү нь ч зөвшөөрсөнгүй, албаны талаас ч таашаасангүй. Ийнхүү Мөөг гуай 1944 онд бага нь 3 настай, том нь 9 настай гурван нялх үрээсээ амьдын хагацал үзсэнээс хойш 44 жил тэднийхээ хэрхэн яаж амь зууж яваа тухай сонсож мэдсэнгүй, айж гайхаж, арга барагдан өнгөрөөсөн нь цагийн байдалтай холбоотой билээ. «Үхтэл үр харам» гэдгээр өнөөг хүртэл энэ буурал эх өнчирүүлэн орхисон гурван үрээ бодсоор л явжээ. Эхээсээ өнчирсэн гурван нялх үрсийн элэг бэтгэрч хичнээн шөнө ээжээ дуудан уйлж, цөхөрлийн мананд умбан аавыгаа зовоосныг Ж. Пүрэв гуай л мэднэ. Олон жил үргэлжилсэн улс төрийн элдэв кампани, хардалт хавчилт, сүрдүүлэлт эхээ санасан үрс, эхнэрээ мөрөөдсөн нөхөрт ямар тустай зүйл хийх билээ. Хоёр улсын харилцаа хөндий хүйтэн болсон сүүлийн 30-аад жилд эдний бодол санаа биелэх ямар ч боломжгүй явж ирснийг хоёр улсын монголчууд сайн мэдэж байгаа.

Харин 1980-аад оны эхээс БНХАУ-ын гадаад дотоод бодлогод өөрчлөлт гарч, хөрш зэргэлдээ улс орнууддаа ханддаг сүрдүүлэх бодлого нь өөрчлөгдөн, нөхөрсөг харьцаанд шилжсэнээр манай хоёр орны хооронд олон жил тогтсон харилцааны хүйтэн цан хүүрэг хайлж эхэлсэн билээ. Үүнд хоёр улсын монголчууд гүн их талархалтайгаар хандаж байна. Олон жил уулзаагүй ах дүү хүмүүс нааш цааш зорчих болж, улмаар бие биеэрээ дамжуулан ах дүүгээ сураглан, чимээ анир авах, захидлаар харилцах, уулзаж учрах явдал ихслээ.

Олон мянган жил айл зэргэлдээ оршиж, хаяа хатган амьдарч ирсэн уламжлалт түүхтэй Монгол, Хятадын ард түмэн хэдийгээр улс хоорондын харилцааны нарийн төвөгтэй, ээдрээтэй замыг туулсан хийгээд үнэн зөвөөр нь марксист байр сууринаас ярьж бичих түүх ихтэй ч гэсэн өнөөдөр хөрш зэргэлдээ хоёр социалист орны хувьд «хэрэлдэж суухаас хэлэлцэж суух нь» хэн хэндээ ашигтай гэдгийг улс төрийн бодлого тодорхойлогчид ойлгох болж байна.

Байдал сүүлийн үед сайжирсантай холбогдон эх үр элэг дэвтээн уулзсан нэг ийм учрал 1988 оны XI сард болсоныг нүдээр үзсэнээ сэтгэлдээ хадгалж явдаг юм. Ээж нь амьд сэрүүн, гэдсэнд ирсэн нэг хүү, нэг охинтойгоо Улаанбаатар хотод байдгийг дуулсан гурван хүү хэд нь амжиж уулзах гэж тэмүүлснийг манай улс дэмжин тусалж ирүүлсэн юм. Тэдний уулзалтыг харсан ямар ч хүнд өр зурсан нэгэн эргэцүүлэл, өөрийн эрхгүй хамар шахируулсан доголлон нулимс авч ирж байсныг мартаж аргагүй. Төрүүлсэн гурван үрээ харсан настай буурал эхийн хөл нь хөшиж, хэл нь гацаж, нүд нь бүрэлзэн, манаран дайвахыг хажуугаас нь харсан хэн боловч өөрийн эрхгүй өрөвдөнө. Баярын учралдаа багтарч байгаа эхээ харсан гурван хүүхэд нь тал талаас нь тэвэрч, амьсгалаа уужиртал алаг нүднээсээ нулимс асгаруулахад сая эхийн сэтгэлийн саатлын товч тайлагдан нам, засаг, төрийн сүлдэндээ залбирахыг бид сэтгэл хөдлөн харсан. 44 жил уулзаж учраагүй эх үрс нэг сарын хугацаанд алийгаа ярьж барах билээ. ӨМӨЗО-ы Алшаа аймгийн Алшаа баруун хошуунд малчин хийдэг 53 настай их охин Дашмаа, 50 настай дунд хүү Ёндон, 47 нас-

тай бага хүү Батбаатар нар ийнхүү төрсөн эхээ 80 нас хүрч байхад ирж золгосон юм. Их охин нь болох малчин Дашмаагийн төрүүлсэн охин Алтанцэцэг одоо Өвөр Монголын Хөх хотод нэртэй дуучин болоод байна. Буурал ээж Мөөг гуайн гэдсэнд 5 сартай БНМАУ-ын торгон хил алхаж ирсэн хүү нь өнөөдөр хотын барилгын газар мэргэжилтнээр ажиллаж байгаа Лундаажанцан юм.

Зуугийн тал насалж яваа гурван хүүхэд нь 80 хүрсэн буурал эхтэйгээ золгож, өвөрт нь ээлжлэн унтаж байгааг бодоход улс хоорондын харилцаанд муу уршиг бий болбол ард түмэн зовдог юм байна гэсэн нэгэн сэтгэлийг эерийн эрхгүй төрүүлж байлаа. Элэг дэвтээн эх үрсийг уулзуулсан өнөөгийн энэ бодлого хувирч өөрчлөгдөхгүй үргэлжилсээр байгаасай гэж хоёр улсын ард түмэн хүснэ.

Эх үрсийн амьдын хагацал гэдгийг бие сэтгэлээр туулсан Ёндон гуай «Би эхээс 6 настай өнчрөн хоцорсон тэртээ 44 жилийн өмнөс хойш өнөөдрийг хүртэл энэ ертөнц дээр тоос хөдөлгөж амьдрахдаа олон гомдож, олон уйлж, мөн ч зарим үед баярлаж явсан. Энэ уулзалт шиг том баяр насандаа үзсэнгүй. Эцэг эх, эх орноосоо хагацах шиг хэцүү юм хүнд байдаггүй байх гэж эхийгээ, өөрийгөө, эгч дүүгээ хараад бодогддог болсон. Улс орнууд бие биеэ ойлгож, ард түмнүүд аз жаргалтай, энх тайван байгаасай л гэж хүсэх юм» гэж ярьсан нь юм үзсэн хүний захиас үг гэж бодогдоно.

Монгол, Хятад хоёр улсын найрамдалт харилцаа 1980-аад оноос олон талаар сэргэж, зарим талаар сайжирч байгаа нь хүмүүст өндөр сэтгэл төрүүлж байна. Монголын ард түмэн хоёр орны найрамдлыг сайн сайхан байлгахын төлөө байгаа бөгөөд үүний дотор худалдаа соёл, урлаг, биеийн тамирын талаар хамтран ажиллахыг нэн чухалд үзэж байгаа юм. Олон жил хаалттай байсан хоёр улсын хил нээгдэж, ард түмэн уулзан учирч, бие биеийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй, бүх зүйлийг үнэн мөнөөр нь ярьж, хэлэлцэж, найрсаг сайхнаар аж төрөх нөхцөл бололцоо бүрдсэн сүүлийн хэдэн жилийн баярт үйл явдлыг гүнзгийрүүлэн батжуулах гэсэн ард түмний хүсэл эрмэлзлэлд нийцүүлэн бичсэн эл өгүүллийн сүүлийг энд хурааж хоёр улсын ард түмэнд эрхэм ёс, энх тайвныг бэлэгдэн ерөөж үгээ дуусган үзгээ эвхэв.

Улаанбаатар 1989 он .

## ХОККАЙДОГООР АЯЛСАН МИНЬ

**М. Нарантуяа**

1988 оны 8-р сарын 17-ноос 9-р сарын 4-нийг хүртэл Японы хамгийн том арал болох Хоккайдоогоор аялах завшаан надад таарав. Жил бүр оюутны зуны амралтаар Хоккайдогийн «олон улсын харилцааны төв»-өөс Япон орныг үзэж, япон гэр бүлд амьдарч тэдний зан заншил, аж байдалтай танилцуулах зорилгоор «Хоум Стэй» буюу «Хоум»-айл,